

СУВИЛАГЧ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАЖ БАЙГАА ОЮУТНУУДЫН СЭТГЭЛ ХӨДЛӨЛӨӨ УДИРДАХ ЧАДАМЖИНД ХИЙСЭН СУДАЛГАА

Д.Хишигжаргал¹ Л.Мөнхчулуун¹

¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль
Khishigjargal.d@mnums.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Б.Мэндхүү

Үндэслэл

1990 онд Питер Саловей, Жон Мейер нар сэтгэл хөдлөлөө удирдах чадамж /EQ/ хэмээх нэршлийг анх гаргаж [2] сэтгэл судлаач, сэтгүүлч Даниэл Гоулмэны “Emotional Intelligence” ном 1995 онд хэвлэгдсэнээр сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийн талаар дэлхий нийт анхаарах болсон байна. Даниэл Гоулмэн сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийг “өөрийнхөө болон бусдын ашигтай үйл ажиллагааг бие махбодиор биш сэтгэлтэй нь харьцан зохицуулах, удирдах мөн хүмүүсийг идэвхижүүлдэг, тэднийг чин сэтгэлээсээ ойлгодог чадвар юм” гэжээ.[3] Сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийг хөгжүүлэхийн тулд заавал тусад нь хичээл орох шаардлагагүй, харин хичээлийн хөтөлбөрүүдэдээ сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийг хөгжүүлэх агуулгыг шингээх үргэлж дадлагажуулах нь үр дүнтэй гэж үздэг байна. Орчин үед бие хүнд хамгийн чухлаар тавигдаж байгаа шаардлага бол бие хүний өөрийн сэтгэл хөдлөлөө хянан зохицуулах, удирдах хандлагаа хөгжүүлэх асуудал юм. Сонголт хийх, шийдвэр гаргах, өөрийгөө дайчлах, бусадтай ойлголцох, бусдад нөлөөлөх гээд амьдралын бүхий л асуудалд хүн сэтгэл хөдлөлөө удирдах хэрэгтэй. Монголд сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын нэг онцлог нь оюутанд академик боловсрол олгоход илүү чиглэсэн бөгөөд хувь хүний үр чадвар, амьдрах чадварын хөтөлбөрүүдийг орхигдуулсан шинжтэй.

Ялангуяа анагаахын мэргэжлээр суралцагсад түүний дотор сувилахуйн оюутнууд сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийг эзэмших шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэхүү судалгаа нь сувилахуйн боловсролд тодорхой хувь нэмэр болно гэж үзэж байна.

Түлхүүр үг:

Сэтгэл хөдлөлөө удирдах чадамж, нийгмийн харилцаа, сувилахуйн боловсрол

Зорилго, зорилт

Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн сувилагч мэргэжлээр суралцагсaдын сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийг шинжих зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

- Сувилагч мэргэжлээр суралцагсaдын сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийн судалгаа авах
- Үнэлгээ, шинжилгээ хийх

Материал арга зүй.

Даниэл Гоулмэний сэтгэл хөдлөлөө удирдах 5 чадамж, 15 шинжийн асуумжаар сувилагч мэргэжлийн 114 оюутнуудын нэг болон хоёр жил суралцсан хугацааны судалгааг авч үзлээ.


Судалгааны ажлын үр дүнг Microsoft office - 2019, статистик боловсруулалтыг SPSS - 20.0 програмыг ашиглан гүйцэтгэсэн.

Хүснэгт 1

№	Шинжүүд	1 жил	2 жил
Бусдыг ойлгох байдал			
1	Ойлгохыг хичээдэг	78(68.4)	82(71.9)
2	Бусдын байр сууринаас харах	35(30.7)	29(25.4)
3	Огт үгүй (ойлгохыг хүсдэггүй)	1(0.08)	3(0.03)
Үгүй гэж хэлж чаддаг уу?			
1	Тийм	32(28.1)	54(47.4)
2	Үгүй	80(70.2)	58(50.8)
3	Заримдаа	2(0.02)	2(0.03)
Өөрийгөө давуу сул талаа мэддэг эсэх			
1	Мэддэг	70(61.4)	75(65.7)

2	Сайн мэддэггүй	44(38.6)	39(34.2)
3	Мэддэггүй	0(0.0)	0(0.0)
Хүнд тусалж чаддаг эсэх			
1	Чаддаг	90(78.9)	93(81.6)
2	Чаддаггүй	22(19.3)	18(15.8)
3	Заримдаа	2(1.8)	3(0.03)
Сайн унтаж амардаг эсэх			
1	Тийм	71(62.3)	66(57.9)
2	Үгүй	43(37.7)	48(42.1)
3	Заримдаа	0(0.0)	0(0.0)
Бүхнийг төгс байлгахыг хичээдэг үү?			
1	Тийм	84(74.2)	62(54.4)
2	Үгүй	18(15.8)	47(41.2)
3	Заримдаа	12(10.5)	5(0.04)
Байгаа зүйлдээ талархаж чаддаг уу?			
1	Үргэлж	38(33.3)	62(54.4)
2	Хааяа	73(64.0)	51(44.7)
3	Бага зэрэг	3(2.6)	1(0.008)
Бусдын сэтгэгдлээс үл хамааран сэтгэл хангалуун байж чаддаг уу?			
1	Тийм	59(51.8)	65(57.0)
2	Заримдаа	54(47.4)	44(38.6)
3	Бага зэрэг	1(0.9)	5(0.04)
БҮГД		114(100)	114(100)

Бусдыг ойлгох байдал нь эхний жилд 68.4%, хоёр дахь жилдээ 71.9%, бусдын байр сууринаас харах нь эхний жилд 30.7%, хоёр дахь жилдээ 25.4%, бусдыг ойлгохыг хүсдэггүй нь эхний жилд 0.08%, хоёр дахь жилдээ 0.03%. Үгүй гэж хэлж чаддаг уу? гэдэгт эхний жилд 28.1%, хоёр дахь жилдээ 47.4% нь тийм, үгүй гэж хэлж чаддаг нь эхний жилд 70.2%, хоёр дахь жилдээ 50.8%, заримдаа үгүй гэж хэлж чаддаггүй нь эхний жилд 0.02%, хоёр дахь жилдээ 0.03%, Өөрийн давуу болон сул талаа мэддэг эсэхэд эхний жилд 61.4%, хоёр дахь жилдээ 65.7% мэддэг, сайн мэдэхгүй нь эхний жилд 38.6%, хоёр дахь жилдээ 34.2% байна.



Зураг 1. Төгс байдал

Судалгаанаас үзэхэд бүхнийг төгс байлгахыг хичээдэг үү? асуултанд эхний жилд 84% нь хоёр дахь жилдээ 62% болж буурсан байна.



Зураг 2. Талархал

Байгаадаа талархаж чаддаг уу? асуултанд эхний жилд үргэлж талархдаг нь 38 оюутан буюу 33.3%, хоёр дахь жилдээ 62 оюутан буюу 54.4%, хааяа гэдэг нь эхний жилд 73 оюутан буюу 64%, хоёр дахь жилд 51 оюутан буюу 44.7% буурсан байна.

Үр дүн

1. Энэхүү судалгаанд хамрагдсан нийт оюутны бусдыг ойлгохыг хичээдэг 82.0%, өөрийхөө давуу ба сул талаа мэддэг нь 75.0% , хүнд тусалж чаддаг нь 81.6% болж өссөн нь сэтгэл хөдлөлөө удирдах чадамж давамгайлж байгаа нь харагдаж байна.

2. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 62% нь бүхнийг төгс байлгахыг хичээдэг, байгаадаа үргэлж талархаж чаддаг нь 33.3% болж буурсан

нь төгс байх боломжгүйг мэдсэнээр алдаагаа давтахгүй түүнээсээ суралцан урагшилж болно гэдгийг харуулж байна.

3. Судалгаанаас үзэхэд суралцах хугацаа ахих тусам сэтгэл хөдлөлөө удирдах чадамж сайжирч байгаа нь ажиглагдаж байна. Цаашид суралцах хугацаанд оюутнуудын сэтгэл хөдлөлөө удирдах чадамжийг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй юм.

SURVEY ON MANAGEMENT SKILLS OF THE EMOTIONAL INTELLIGENCE IN NURSING STUDENTS

*The term emotional intelligence was created by two researchers, **Peter Salavoy and John Mayer** in their article "Emotional Intelligence" in the journal Imagination, Cognition, and Personality in 1990. It was later popularized by Dan Goleman in his 1996 book Emotional Intelligence. *Educating the mind without educating the heart is no education at all. Aristotle. Educating the heart refers to the importance of not only focusing on developing the cognitive aspects (our minds) but also all the qualities that make us human (our hearts) and ultimately give us meaning in our lives. [2]**

"Emotional intelligence is the ability to perceive emotions, to access and generate emotions so as to assist thought, to understand emotions and emotional knowledge and to reflectively regulate emotions so as to promote emotional and intellectual growth. [3]

It is not necessary to take separate classes to develop students' ability to manage their emotions, but it is considered effective to incorporate content into the curriculum. The most important requirement for the individual today is to develop an attitude of controlling and managing one's emotions. One has to control one's emotions in all aspects of life, such as making choices, making decisions, mobilizing oneself, understanding others, and influencing others. One of the features of educational institutions in Mongolia is that they are more focused on providing academic education to students and tend to omit individual skills and life skills programs. Especially medical students, including nursing students, need to be able to manage their emotions. This study is expected to make a significant contribution to nursing education.

1. The total number of students surveyed increased to 82.0% who tried to understand others, 75.0% who knew their strengths and weaknesses, and 81.6% who were able to help others, indicating an increase in students' ability to control their emotions.

2. Of the students surveyed, 62% said they try to be perfect, 33.3% were always grateful for their presence, but they knew they could not be perfect, so they could learn from their mistakes without repeating them.

3. The studies show that the longer the students study, the better their ability to control their emotions. This is more effective for nursing students.

Ном зүй

1. Боловсрол судлал 2017 он "EQ сайжруулахын тулд хэрэгжүүлэх 4 алхам"
2. Г.Сарантуяа "Сэтгэл судлалын шинжлэх ухааны судалгааны аргууд" 2015 он УБ
3. Б.Батсайхан, М.Дэлгэржав "Ерөнхий сэтгэл судлал" 2015 он УБ
4. 10.Б.Оюумаа "Хандлага бол таны сэтгэлгээний нэг чадвар юм" 2016 он УБ
5. О.Мягмар "Хүний хөгжилийн сэтгэл зүйн лекцүүд" 2014 он УБ